

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Завхан аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төв

Төвийн дарга М.Заяат

Холбоо барих утас: 88700320, 98119412

Цахим хаяг: zavkhan@namem.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025-12-30


Улиастай


Манай байгууллага нь 2025 онд нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.


2025 онд дараах зорилтыг тавьж ажиллаж байна.

- ▶ Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах


ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮТЭЭЛЧ АЖЛУУД:

 Аймгийн Засаг дарга Г.Өнөрбаяр 2025 оны 01 сарын 27-нд манай байгууллагад ажиллаж албан хаагчидтай уулзсан. Уг уулзалтаар манай байгууллага болон даргын үйл ажиллагааг дэмжиж цаг уурын байгууллагыг дэмжсэн бодлого, хөрөнгө оруулалтыг хийх болно гэдгээ илэрхийлсний дагуу дараах хөрөнгө оруулалтыг ЗДТГ-аас авч ажиллалаа.




 Аймгийн Засаг даргын 2025 оны А16 дугаар захирамжаар шийдвэрлэгдсэн 20 сая төгрөгөөс байгууллагын архивын өрөөний стандарт хангах, архивын улсын үзлэг угтаж Миракл Полар Рэй ХХК-аас 6 ширхэг нягтруулах шүүгээ 8,4 сая төгрөгөөр худалдан авч суурилуулсан.





 Манай байгууллага нь аймгийн төвөөс алслагдмал байгууллагын орчинд цайны газар байдаггүй албан хаагчид үдийн цайгаа гэрээс зөөх эсвэл аймгийн төв рүү явж цайнд ордог тул албан хаагчийн үдийн цайны өрөөний тохижилтод Арина Компьютерс ХХК-аас 2,4 сая төгрөгөөр усны аппарат, хөргөгч, тоос сорогч, печь, Говь хангай мебель ХХК-аас 2,2 сая төгрөгөөр гал тогооны тавилга, Некст электроникс ХХК-аас 1,8 сая төгрөгөөр шарах шүүгээ, будаа агшаагч гэх мэт гал тогооны бусад эд зүйл худалдан авч суурилуулсан нь албан хаагчдын ажлын цаг ашиглалтад сайнаар нөлөөлсөн.





 Алтан-Наруул ХХК-аас 1,1 сая төгрөгөөр ширээ 2, сандал 4 ширхэг, ээлжийн албан хаагчдад шүүгээ 1 ширхэг, БСБ Коммерс ХХК-аас олон үйлдэлт өнгөт принтер 1 ширхгийг худалдан авч албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжрууллаа.




 Байгууллагын конторын барилга албан хаагчдад өрөө тасалгааны хүрэлцээ муу, маш их дулаан алддаг, 2024 онд засвар хийсэн боловч буцаад мөөгөнцөртөж, дулаан алдаж эхэлсэн тул конторын барилга шинээр барих саналыг аймгийн Засаг даргад тавьсан. Уг саналыг Засаг дарга дэмжин 2 давхар барилгын зураг төсвийг ЗДТГ-аас 92,7 сая төгрөгөөр хийлгэсэн.


 Шинээр баригдах конторын төсөв 4.5 тэрбум төгрөгийн 2026 оны Улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлэн ажиллаа.

 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Баянтэс сумдын Цаг уурын өртөөний барилга баригдахаар төлөвлөгдсөн тул барилгын зургийн компанид холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэн ажиллаж байна.


 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Everest Cross 200ccZS200GY-3 маркийн мотоцикл 5 ширхгийг авч Гадаргын ус судлалын харуулын албан хаагчдад хүлээлгэн өгсөн.




 Аймгийн Засаг даргын тамгын газрын ОНХС 15,0 сая төгрөгийн хөрөнгийг тусгуулан Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулсан.


 Аймгийн Засаг даргын Шувуун харуул ХХК-тай байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Говийн сумдад цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэхэд 20 сая төгрөгийг тусгуулсан. Үүнээс 2025 онд 5,0 сая төгрөгөөр нь Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бие бүрэлдэхүүнд Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл авч өгсөн.




 Богдын голын гүүрэн дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Австри улсад үйлдвэрлэсэн RQ-30 усны түвшин, урсгалын хурд хэмжигч автомат төхөөрөмжийг 10 дугаар сард суурилууллаа. Улиастай сумын ЗДТГ-аас автомат төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай 485000 төгрөг шийдвэрлүүлэн ажиллаа.




 Аймгийн Засаг дарга, Байгаль орчин уур амьсгал, өөрчлөлтийн сайд нарын “Байгаль орчин, уур амьсгалын салбарт хамтран ажиллах” гэрээний тусгагдсан мөнгөнөөс Агаарын чанарын автомат станц суурилуулахад 5 сая, автомат станцын тасралтгүй ажиллагааны цахилгааны төлбөр 4,7 сая, нийт 9,7 сая төгрөг шийдвэрлүүлсэн.

 Сумдын масс мессеж модем төхөөрөмжийн тасралтгүй ажиллагааг хангаж орон нутгийн 24 сумдын ЗДТГ-аас 9.8 сая төгрөг шийдүүлэн модемын сунгалтаа бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

 Аймгийн ИТХ-н хуралд горимын санал оруулж Тайланд улсын хур тунадас нэмэгдүүлэх зориулалттай суурин газрын генератор 2 ширхгийг аймгийн 2026 оны төсөвт, мөн УИХ-н гишүүн Б.Түвшинд хүсэлт гарган 1 ширхгийг шийдвэрлүүлсэн.

ОРОН НУТГИЙН САЛБАРУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОНЦЛОХ АЖЛУУД:

 Орон нутгийн өртөөдийн 2025 оны ажлын гүйцэтгэл, онцлох ажил, хөрөнгө оруулалтын талаар 12 дугаар сарын 2-нд цахим тайлан тавиулж Даргын зөвлөлөөр хэлэлцүүлээ.



❖ Цэцэн-Уул сумын цаг уурын өртөөний хамт олон нь 2025 онд Засаг даргын нөөц сангаас 15 сая төгрөг шийдвэрлүүлж өртөөндөө засварын ажил хийж гүйцэтгэсэн.

1. Урд цонх вакум-1ш

- Дундуураа нэг тасалгаатай, 2 поорчигтой байх
- Поорчиг хэмжээ: урт-1м60см өргөн-40см
- Хэмжээ: урт- 1м60см өргөн-2м50см

Урд цонх тавцан-1ш

- Чулуун тавцан, байгалийн өнгөтэй
- Хэмжээ: урт-25см өргөн-30см

2. Арын цонх вакум-2ш

- Тасалгаагүй 1 поорчигтой
- Поорчиг хэмжээ: урт-53см өргөн-30см
- Цонх хэмжээ: урт-1м45см өргөн-1м25см

Урд цонх тавцан-1ш

- Чулуун тавцан, байгалийн өнгөтэй
- Хэмжээ: урт-25см өргөн-30см


3. Хаалга-2ш

- Төмөр хаалга бор өнгөтэй
- Хэмжээ: урт-210см өргөн-96см
- Вакум хаалга цагаан өнгөтэй

- Хэмжээ: урт-210см өргөн-96см
- 4. Тааз 2 өрөө 40мкв
 - Лампир. Шаргал өнгөтэй
 - Урд өрөө хэмжээ: урт-4м96см өргөн-4м15см
 - Хойд өрөө хэмжээ: урт-6м10см өргөн-3м
- 5. Дотор засвар 2 өрөө 40мкв
 - Рейк модоор хийсэн. Шаргал өнгөтэй
 - Дулаалга шилэн хөвөнгөөр.
 - Урд өрөө хэмжээ: өндөр-2м70см өргөн-4м15см
 - Хойд өрөө хэмжээ: өндөр-2м70см өргөн-3м

Өртөөнийхөө өнгө үзэмж, тав тухтай орчныг бүрдүүлж өртөөний хамт олон 2,5 сая төгрөгийн эд материалыг авсан.

- Хөшиг, чүүл-1ш
- Гэрэл тааз-2ш хана-1ш
- Хулдаас 2 өрөө 40мкв талбайд 20м
- Ус буцалгагч-1ш
- Сандал-2ш
- Ажлын ширээ-1ш
- Монтажны утас, далдлагч-10м



❖ Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газраас Автомат станцад газардуулга хийх материалын зардал 2,7 сая төгрөгийг шийдвэрлүүлж газардуулгыг 5 сард стандартын дагуу хийж гүйцэтгэв.



❖ Отгон сумын Засаг даргын тамгын газраас Автомат станцын газардуулга хийхэд шаардлагатай 2,7 төгрөг шийдвэрлүүлсэн бөгөөд бараа материалын захиалгыг хийсэн 2026 онд газардуулгыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

❖ Дөрвөлжин сум Цаг уурын өртөө нь сумын ЗДТГ-ын сум, багийг дэмжих сангаас 7,3 сая төгрөг шийдвэрлүүлж иж бүрэн компьютер, өнгөт принтер авсан.



❖ Нийт 173,8 сая төгрөг хөрөнгө оруулалт авсан байна.

Нэг. “ Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд

Монгол улсын Засгийн газар тогтоол, хөтөлбөр, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал, шийдвэр, Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, Ус цаг уур, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлох, мэдээ мэдээллийн шуурхай, ил тод, хүртээмжтэй байдал, шинжилгээний ажлын тасралтгүй ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ, мэдээлэл, тайланг цаг хугацаанд хүргүүлэн ажиллаж ирлээ.

-Дээд газраас батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Удирдах ажилтны сургалт семинар 4 сард Улаанбаатар хотод зохион байгуулагдан дарга М.Заяат хамрагдсан.

-Иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын бодит болон ажиглалтын мэдээгээр үйлчлэх техникчдийн давтан сургалт 4 сард Улаанбаатар хотод зохион байгуулагдан М.Чанцалмаа хамрагдсан.

-Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцах 4 сард Улаанбаатар хотод зохион байгуулагдан ЦАЗН ХХАА технологич инженер С.Мөнх-Очир, Жолооч С.Гантулга нар хамрагдсан.

-Шалган тохируулгын ажилтны эрх олгох сургалт 4 сард Улаанбаатар хотод зохион байгуулагдан Хэмжих хэрэгсэл хэмжлийн технологи хариуцсан технологич инженер Ж.Отгонбаяр хамрагдсан байна.

-Байгаль орчны салбарын стандарт, эрх зүйн шинэчлэл хэлэлцүүлэг 02 сарын 19-20-нд, Агаарын бохирдлын эх үүсвэрийн хаягдлын тооллогын сургаалтанд 02 сарын 19-нд тус бүр лабораторийн эрхлэгч, ЧМ З.Балжинням танхимаар 3 инженер цахимаар хамрагдсан.



Агаарын бохирдол хэлэлцүүлэг



-2025 оны 10 сарын 06-13-ны өдрүүдэд онлайн хэлбэрээр давтан сургалт хийж, бүх синоптик инженерүүд идэвхтэй оролцож шалгалтаа 96-100 хувь гүйцэтгэж сертификат авсан.



-10 сарын 18-20 оны өдөр Мэдээллийн технологид суурилсан агаарын чанарын хяналтын нэгдсэн системийг бий болох сургалтад З.Балжинням, Г.Нямсүрэн нар 11 сарын 18-21-нд Агаарын чанарыг хянах автомат суурин багажид гарсан гэмтлийг оношлох, шалгах, засвар үйлчилгээ хийхэд чадавхыг сайжруулах, агаарын чанарын мэдээг боловсруулах сургалтад З.Балжинням, Б.Мягмар нар хамрагдлаа.

Дээд газраас ирсэн сургалтын төлөвлөгөөний дагуу 7 удаагийн сургалтад нийт 14 хүн хамрагдсан.

2. Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу

-Орон нутгийн албан хаагчдад 2 дугаар сарын 3-нд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хэрэгжилт гаргах талаар 2 цагийн цахим сургалтыг байгууллагын хяналт үнэлгээний хэсгээс зохион байгуулсан./62 хүн/

-2025 оны дотоодод хийгдэх сургалтын хөтөлбөрийн дагуу өртөө, харуулын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 4 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгууллаа.

-Шинжилгээний ажлын технологи мөрдөлт, гарч буй алдаа дутагдлын талаар салбар хариуцсан инженер техникч нар хичээл бэлдэж, дадлага ажил хийлгэн алдааг дахин давтаж гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгч, хичээл заалаа. Уг сургалтад Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Аймгийн онцгой байдлын газраас тус тус мэргэжилтнүүд оролцуулж Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, малчид ард иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх талаар мэдээлэл хийж хичээл заав. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй ба харилцаа хандлага сэдвээр хичээл заагдсан болно.



Сургалтад орон нутгийн цаг уурын өртөөний дарга-8, өртөөний ээлжийн техникч-8, харуулын ажиглагч-14 нийт 30 албан хаагч хамрагдсан.

-2024 онд шинжилгээний ажлаараа сүүлийн байрт орсон шинжилгээний ажлын чанар төдийлөн ахихгүй байгаа Баянтэс өртөөний албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор ажил сайжруулах тухай цахим хэлэлцүүлгийг 2 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж хэлэлцүүлгийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргуулан баталгаажуулж хэрэгжилтийг гаргуулан ажиллаж байна.

-Улиастай өртөөний техникч нарт болон МҮХ-ийн 2 техникчид үүлний ажиглалт, үүл үзэгдлийн уялдааны талаар 2 цагийн хичээл заасан. Баянтэс өртөөний дарга болон техникч нарт онлайнаар хичээл зааж, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж ажилласан.

-Улиастай өртөөний техникч нарт үзэгдэлтэй үед байнга зааварчилга зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Үүрэг даалгавар өгч, шалгаж үнэлгээ өгч ажиллаж байна.

-Шинжилгээний ажилд анхаарах шаардлагатай зарим салбаруудын ажиглагч, техникч нарыг давтан сургалтад хамруулах төлөвлөгөөний дагуу Дөрвөлжин, Завханмандал өртөөний дарга, 4 өртөөний нийт 9 техникч, Тэлмэн харуулын ажиглагч нийт 12 хүнд тус бүр 6-10 цагийн хичээл зааж, дадлага хийлгэж, зааварчилга өгсөн.

Давтан сургалтад дадлага ажил хийж буй нь.



-Шинээр ажилд орсон хүмүүст хөтөлбөр боловсруулан, даргаар батлуулан ажилласан байна. Завханмандал өртөөний техникчээр Г. Долгорсүрэн, Хайнзан-Авгаан, Нөмрөг өртөөний техникч Бямбажаргал, Дөрвөлжин өртөөний техникч Жанцанхорол, Цэцэн-Уул өртөөний техникч Лхагвазаяа, Тосонцэнгэл өртөөний техникч Цэндсүрэн, Батчимэг нарт тус бүр 160 цагийн хичээл зааж, дагалдуулан сургасан. Энэ онд нийтдээ 7 хүнийг сургаж дадлагажуулан ажиллууллаа. Сургалтын явцад хариуцсан инженер шалгалт авч, давтан сургах арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан. Ажилд орсноос хойш өдөр бүр өртөөний даргатай зөвлөлдөн ажиглалт мэдээлэлд хяналт тавин хамтран ажиллаж байна.

Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 120 хүн хамрагдсан.

Төлөвлөгдөөгүй сургалт:

-Байгаль орчны мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт 02 сарын 03- 06-нд Эрдэнэт, Улаанбаатар хотод явагдаж лабораторийн эрхлэгч, ЧМ З.Балжинням танхимаар хамрагдсан.



Байгаль орчны чадавхжуулах сургалт

-Байгаль орчны газраас 03 сарын 19-нд зохион байгуулсан баруун бүсийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөний төсөлтэй танилцах, туршлага солилцох салбар форум” сургалтад хамрагдсан.



Байгаль орчны салбарын стандарт хэлэлцүүлэг

-04 сард Хятад улсад зохион байгуулагдсан Кантон Фэйр болон импортын үндсэн мэдлэг олгох 8 цагийн сургалтад Дарга М.Заяат хамрагдаж сертификат авсан.

-ЦУОШГ-ын Газраас Удирдлагын академиас Удирдах ажилтны, ур чадвар манлайлал сэдэвт 16 цагийн сургалт зохион байгуулж Дарга М.Заяат хамрагдаж сертификат авсан.



-04 сарын 23-ны өдөр зохион байгуулсан Дэлхийн итгэмжлэгдсэн лабораторийн хэлэлцүүлэгт оролцож орон нутагт тулгамдаж буй асуудлаар ярилцлага өгсөн.



Дэлхийн лабораторийн өдөр

-03 сарын 25-нд Онцгой байдлын газраас “Газар хөдлөлт”-ийн талаар сургалтыг танхимаар зохион байгуулсан. 03 сарын 27-нд Гамшгаас хамгаалах команд штабын сургалтад бие бүрэлдэхүүнээрээ оролцсон. /30 хүн/



Ажлын байрны сургалт



Хаягдлын тооллого сургалт



Команд штабын сургалт



Агаарын чанарын автомат станц сургалт

-Ховд аймагт зохион байгуулагдсан Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал баруун бүсийн албан хаагчдын зөвлөгөөн 5 сард зохион байгуулагдаж Дарга С.Заяат оролцсон.



-“Жендерийн тэгш байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” олон улсын хурал угтсан зөвлөлдөх уулзалтад оролцож, тулгамдаж буй асуудал, арга хэмжээ, санал, уриалга гаргахад 4 хүн оролцсон.



- 5 дугаар сард Улаанбаатар хотод " WE WOMEN" Бид эмэгтэйчүүд чуулга уулзалт Монгол улсын Төрийн ордонд зохион байгуулагдаж Дарга М.Заяат оролцсон.



-6 дугаар Өвөрхангай аймгийн Хужирт суманд Удирдлагын академи, Төсвийн удирдлагын хүрээлэнтэй хамтран иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадвахжуулах сургалтад Дарга М.Заяат хамрагдсан.



-6 дугаар сард Улаанбаатар хотод Уур амьсгалын өөрчлөлт ба орон нутгийн төлөвлөлт форумд Дарга М.Заяат оролцсон.



-Улиастай суманд 7 дугаар сард зохион байгуулагдсан Бүс орон нутгийн хөгжилд нутгийн удирдлагын байгууллагын оролцоо сэдэвт сургалт, гэмт хэрэг, зөвлөлөөс урьдчилан сэргийлэх баруун бүсийн салбар зөвлөлүүдийн зөвлөгөөнд Дарга М.Заяат оролцсон.



-09 сарын 23-28-нд Солонгос улсад Агаарын чанарын автомат станцын тоног төхөөрөмжийг суурилуулж танхимын болон дадлага сургалтад Б.Мягмар хамрагдсан.



-2025 оны 10 дугаар сарын 13-14-нд Төрийн болог орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн программын сургалтад Нягтлан бодогч хамрагдсан.

-2025.10.21-нд Аймгийн ЗДТГ-ын Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс Авлигын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, албан хаагчийн ёсзүйн хууль, дүрмийн талаар сургалт авч төвийн албан хаагчид танхимаар, орон нутгийн албан хаагчид онлайнаар хамрагдлаа.

-Жендерийн бодлого, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах нь бүсийн семинарт Дарга М.Заяат хамрагдсан.



-НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яамны техник хамтын ажиллагааны “Монгол улсын бэлчээрийн мал аж ахуйд суурилсан амьжиргааны гамшгийн эрсдэл даах чадварыг дээшлүүлж цаашид тохиолдох гамшигт нэрвэгдэх байдлыг бууруулах” TCP/MON/4002 төслийн хүрээнд “ Уур амьсгал ухаалаг аж ахуй ба мал аж ахуйн гамшгийн эрсдэлийн удирдлага” сургалтад Дарга М.Заяат хамрагдсан.



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

-Ус цаг уур, орчны шинжилгээний ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн журам, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журмыг сумдын Цаг уурын өртөөний дарга нар, харуулын техникч нарт 4 дүгээр сарын 3-4-ний хооронд Аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Б.Болорчулууныг авчирч сургалт оруулж зааварчилгаа өгч гарын үсэг зуруулж, баталгаажуулалт хийж ажилласан. Аймгийн төвд ажиллаж байгаа инженер, техникийн 37 ажилтан нийт 98 албан хаагч нарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн журам, галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж ажиллах талаар зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

-Байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер, техникч, “Завхан Бороо-1” экспедицийн бие бүрэлдэхүүнд бусад ажилтан нарт хөдөө орон нутагт ажиллах үед замын хөдөлгөөний болон бусад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч баталгаажуулалт хийлгэн ажиллаа.

-Тосонцэнгэл сумын Ус судлалын харуулд 330,0 төгрөгийн тросс, автомат станцад 1,7 сая төгрөгийн хэрэгсэл авч өгсөн.

-Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллаж байгаа Байгаль орчны лабораторийн албан хаагчдад 5,6 сая төгрөгийн хор саармагжуулалтын мөнгө олгосон байна.

-БОШЛ- албан хаагч нарт хөдөлмөр хамгааллын нэг удаагийн хувцас, аптекий иж бүрэн хангалт, резинэн бээлий, маск, 00 цаас гарын шингэн саван, сав суулгах угаах шингэн, зай, усны харуулын ажиглагч нарт зай зэрэг 2,2 сая хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангаж ажилласан байна.

-7 өртөө болон аймгийн төвийн байрны галын аюулгүй байдлыг хангах зорилгоор 25 ширхэг галын хорыг 1,1 сая төгрөгөөр авсан.

-Аймгийн Засаг дарга, уул уурхайн Шувуун харуул ХХК-тай хамтран ажиллах 4 жилийн хугацаатай гурвалсан гэрээнд 20 сая төгрөг тусгуулсан. Үүнээс 2025 онд 5 сая төгрөгөөр нь Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн бие бүрэлдэхүүнд Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл авч өгсөн.

14. АХМАДЫН САНГИЙН ХҮРЭЭНД:

-Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2024 оны 12 дугаар сард Ахмадын санг үүсгэн байгуулж 40 сая төгрөг төвлөрүүлсэн. Үүнээс Ахмадын сангийн журмын дагуу сар шинийн баяраар төв болон орон нутагт амьдардаг байгууллага харьяалалтай нийт 35 ахмадад нэг хүнд 100 мянга, нийт 3,5 сая төгрөг өгсөн.

-Сар шинээр аймгийн төвд амьдарч байгаа ахмадуудыг хүлээн авах тавгийн идээ, цайнд 500 мянган төгрөг зарцуулсан.



-6 дугаар сарын 01-нд одонтой ахмад эхчүүд 19 хүнд нэг 100 мянга, нийт 1,900,000 төгрөг олгож хүндэтгэл үзүүлсэн.


-10 дугаар сарын 01-ний Ахмад настны өдрөөр байгууллагын нийт 37 ахмадад нэг хүнд 200,000, нийт 7,400,000 төгрөгний хүндэтгэл үзүүлсэн.

-Мөн гэр хороололд амьдардаг 28 ахмадад түлээ нүүрсний хөнгөлөлт нэг хүнд 300,000, нийт 8,400,000 төгрөгний тусламж үзүүлсэн.

ШАГНАЛ: Цаг уурын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж Цаг уурчдын өдрөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамны тэргүүний ажилтнаар 4, Жуух бичгээр 2, Цаг уур орчны шинжилгээний газрын Жуух бичгээр 5 албан хаагч шагнагдсан.



Ардын хувьсгалын 104 жилийн ойн байр наадмыг тохиолдуулан Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тэргүүний ажилтан цол тэмдгээр 4 хүн, Хүндэт жуухаар 2 хүн шагнагдсан байна.



-БОУАӨ-ийн сайд Б.Батбаатар /2025.08.12/ Завхан аймгийн Байгаль орчны салбарын албан хаагчидтай уулзлаа. Уулзалтын үеэр яамны Тэргүүний ажилтан цол тэмдгээр 2, Жуух бичгээр 2 албан хаагч шагнагдлаа.



-Улсын их хурлын гишүүн Б.Түвшинг Завхан аймагт ажиллах үеэр Төрийн дээд одон Алтан гадас одонгоор 2 хүн, Хөдөлмөрийн хүндэт медалиар 3 хүн шагнагдлаа.



НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ. Ус цаг уур орчны шинжилгээний төв нь “ШИНЭЧЛЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ” аяны хүрээнд “МЭРГЭЖИЛ СУРТАЛЧЛАХ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ 2025 оны 06 сарын 05-нд

аймгийн Нутгийн ордны өмнөх төв талбайд 12 цагаас 16 цаг хүртэл зохион байгууллаа.

Уг өдөрлөгөөр Цаг уурын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил бүхнээр сурталчилж, цаг уурын бүх төрлийн мэдээллийг ард иргэдэд тараалаа. Мөн МУИС, Дархан ХААИС-ын Цаг уур, ус судлалын тэнхимийн бакалаврын хөтөлбөрийг 12 дугаар анги төгсөж буй сурагчдад сурталчлан таниуллаа. 12 дугаар анги төгсөж буй сурагчдын байгууллага дээр урьж байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь сурталчилж байгууллагаа танилцуулсан.

Өдөрлөгт ирсэн ард иргэдээс цаг уурын байгууллага, мэдээ мэдээллийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг нийт 76 хүнээс 5 асуултаар санал авахад 69 хүн буюу 90.98 хувь САЙН гэж дүгнэгдсэн байна.



06-сарын 05-нд орон нутгийн бүх өртөө, харуул өөрсдийн ажиглалтын талбай, ажлын байранд төгсөх ангийн сурагчдыг урьж ажлаа танилцуулж, МУИС, Дархан ХААИС-ын Цаг уур, ус судлалын тэнхимийн бакалаврын хөтөлбөрийг танилцуулан ажилласан.



Тосонцэнгэл сумын цаг уурын Өртөөнд 06 сарын 06-нд байгууллагаараа очиж “МЭРГЭЖИЛ СУРТАЛЧЛАХ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ зохион байгууллаа.



ТАЙЛАН БИЧСЭН: ДАРГА

М.ЗАЯАТ